



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/332

Мөрөн сум

Чоно агнах зөвшөөрөл олгох  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2.2, Амьтны тухай хуулийн Амьтны тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 5.5.1, 35 дугаар зүйлийн 35.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/376 тоот тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXV хуралдааны 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд байгалийн тэнцлийг хангах, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авах зорилгоор агнах чонын тоо хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тоо хэмжээний дээд хязгаарт багтаан зөвшөөрлийг олгож удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ



6712011033

Захирамж 2024



Аймгийн Засаг даргын 2024 оны...07-дугаар  
Сарын...01-ны өдрийн...132-дугаар  
захирамжийн хавсралт

Чонын тоо толгой зохицуулах зорилгоор агнах чонын тоо хэмжээ

№	Сумын нэр	Агнах чонын тоо толгой
1	Рэнчинлхүмбэ	10
2	Тариалан	20
3	Бүрэнтогтох	15
4	Улаан-Уул	15
5	Цагаан-Уул	5
6	Цагаан-Үүр	30
7	Чандмань-Өндөр	35
8	Эрдэнэбулган	25
9	Тосонцэнгэл	10
10	Их-уул	10
11	Төмөрбулаг	5
12	Хатгал	5
13	Галт	5
14	Жаргалант	5
15	Ханх	5
Нийт		200